



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/21/СТА-ТТЗ

Баянхонгор хот. 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 7044-2584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Цэцэгмаа
Утас: 7044-2424 Цахим хаяг: tsetsegmaad@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Должмаа
Утас: 88119345 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn
Аудитор: Г.Ганчимэг
Утас: 88268424 Цахим хаяг: Ganaa_7133@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .	10
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл	11
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	11
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3	Менежментийн захидал	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	18
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	20

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.03.25 № 2/161
танай _____-ны № _____-т

Г Аудитын гэрчилгээ Г

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Д.МӨНХБАТ ТАНАА Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

2519308

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Нийгмийн даатгалын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч Д.Мөнхбатад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.03.21-нээс 2019.03.25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.03.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа, аудитор Г.Ганчимэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.03.05-ны өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Нийгмийн даатгалын хэлтсийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Нийгмийн даатгалын хэлтэс нь "Даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Нийгмийн даатгалын хэлтсийн удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
- Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байхгүй.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нийгмийн даатгалын хэлтсийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Нийгмийн даатгалын хэлтэс санхүүгийн тайланг бэлтгэхдээ НДЕГ-ын санхүүгийн нэгдсэн цогц программ хангамж ашигладаг байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөгүй гэж үзлээ.

Нийгмийн даатгалын хэлтсийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийжээ. Аудитаар зөрчил илрээгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Нийгмийн даатгалын хэлтсийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн зардлын дүнгээс 1,0 хувиар сонгов.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 74467003,0 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 744670,0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илрээгүй.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захиаргчийн хэмжээнд 2269,1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрч, 1410,0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 869,1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, дахин давтахгүй байх зөвлөмж өгч, 98475,9 мянган төгрөгийн алдаанд залруулга хийсэн.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангилалаар үзүүлэв. Үүнд:

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчын шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Үүнээс: Залруулгын ангилал

№	Залруулгын товч утга	Мөнгөн дүн (мянган төгрөгөөр)	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой	Тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа	Өмнөх тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа	Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлттэй холбоотой
1	Дахин үнэлгээ хийсэн барилгын хуримтлагдсан элэгдэл 98,4 сая төгрөгийн дансны бичилтийг буруу хийж, өмнөх үеийн үр дүнгийн дансанд бүртгэсэн.	98475,9	98475,9			
	Дүн	98475,9	98475,9			

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	859.1	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	1410.0	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	2	2269.1	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Зардлын данстай холбоотой асуудал.

Тайлант хугацаанд олгосон цалингийн зардлын гүйлгээг цалингийн цэстээс давтан тооцоолж баталгаажуулахад 100.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалинг авлагаар тусгаагүй, жилийн эцсийн үр дүнгийн урамшууллыг бодож олгохдоо Хэлтсийн даргын зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу олгоогүй 1310.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16.5.5 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоосон.

2.8.2.1. Зардлын данстай холбоотой асуудал.

Тус газар нь барилга байгууламжийн дахин үнэлгээг СС-ын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хийж мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан байна. Дахин үнэлгээгээр 3 барилга, 4 байгууламжид дахин үнэлгээ хийж, 2689 м.кв газрыг 67,2 сая төгрөгөөр үнэлж санхүүгийн тайланд тусгасан байна. Дахин үнэлгээ хийсэн барилгын хуримтлагдсан элэгдэл 98,4 сая төгрөгийн дансны бичилтийг буруу хийж, өмнөх үеийн үр дүнд дансанд бичилт хийсэн байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2018 оны 207 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.

Оны эцэст ажиллагсдын ажлын үнэлж үр дүнгийн урамшуулал олгохдоо анх гаргасан шийдвэрийн дагуу бодож олгоогүй, үр дүнг олгох талаар хэлэлцсэн хурлын тэмдэглэлд зарим ажиллагсдын үнэлгээг оруулаагүй, үнэлгээг тодорхой тусгаагүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Нийгмийн даатгалын хэлтэс чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 6 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 40840336,8 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зарлагын нийт гүйцэтгэл 40663639,3 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь дараах шалтгаантай байна. Үүнд: Тайлант онд ҮОМШӨ-ны зардал гараагүй, интернетийн төлбөрийг ҮЭ-хорооноос шилжүүлснээс холбооны зардал 558,3 мянган төгрөгөөр хэмнэгдсэн, банкны үйлчилгээний хураамжийн зардал 1500,0 мянга, бараа

үйлчилгээний бусад зардал 1700,0 мянган төгрөгөөр хэмнэгдэж, бичиг хэргийн зардал 421,4 мянга, багаж техник хэрэгслийн зардал 127,6 мянган төгрөгийн төгрөгөөр хэтэрсэн байна.

Нийгмийн даатгалын хэлтэс өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө батлагдаагүй бөгөөд гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогоор 9,3 сая, туслах үйл ажиллагааны орлогоор 1,1 сая төгрөг орсон байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Нийгмийн даатгалын хэлтэс Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 50% хувьтай байна.

2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2 зөвлөмж өгсөн байна. Хэрэгжилтийг тооцож үзэхэд аудитаар “Төсвийн тухай хуулийн 8.9.2 дахь заалтыг мөрдөж цаашид төрийн аудитын байгууллагад санхүүгийн нэгтгэсэн тайланг цаг хугацаанд нь хүргүүлэн ажиллах” зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хугацаа хоцроож ирүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийн 97.7 хувь буюу 98475.9 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 1.4 хувь буюу 1410.0 мянган төгрөгийн зөрчилд хохирлыг барагдуулах төлбөрийн акт тогтоож, 0.9 хувь буюу 859.1 мянган төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

(Мянган төгрөг)

№	Байгууллагын ангилал	Илрүүлэлт						Залруулга	
		Зөрчил		Алдаа		Бүгд дүн		Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТТЗ	2	2269.1	1	98475.9	3	100745.0	1	98475.9
2	ТШЗ								
3	ТБӨААН								
	Дүн	2	2269.1	1	98475.9	3	100745.0	1	98475.9

Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

(Мянган төгрөг)

Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗ	2	2269.1	1	1410.0	-	-	1	859.1	-	-	-	-
2	ТШЗ												
3	ТБӨӨААН												
	Дүн	2	2269.1	1	1410.0	-	-	1	859.1	-	-	-	-

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Нийгмийн даатгалын хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Өглөг, авлагын тооцоог мөнгөн хөрөнгийн журнал, харилцахын баримтаас харилцагч байгууллагуудын нэхэмжлэл, тооцоо нийлсэн актаар тулган баталгаажуулахад ХХОАТ-ын хөнгөлөлтийн тооцоог буруу тооцож албан хаагчдаас 566.6 мянган төгрөгийн татварыг илүү суутгасан, 302.5 мянган төгрөгийн татварыг суутгаж авсан боловч шилжүүлээгүй Татварын хэлтэстэй өглөг, авлагын тооцоо нийлээгүй санхүүгийн тайланд өглөг авлагыг бүрэн тусгаагүй байна.

Энэ нь Эрх ба үүрэг, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэл хөтлөх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, ХХОАТ-ын хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлий тухай хуулийн 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлж, авлага, өглөгийг санхүүгийн тайланд зөв тайлагнах, тайлант жилд харилцагч байгууллагатай тооцоог үнэн зөв хийж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Саналгүй.

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: Албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлсэн хэлтсийн даргын зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хянаагүй, хурлын тэмдэглэлд зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийг бүрэн тусгаагүй, үр дүнгийн үнэлгээ болон мөнгөн дүнг тодорхой бичээгүй хоорондоо харилцан адилгүй хурлын тэмдэглэлүүд гарсан байна.

Энэ нь Эрх ба үүрэг, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, 16.5.5 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл: Хууль, дүрэм, журам хэрэгжүүлээгүйгээс төсвийн хөрөнгө зүй бусаар зарцуулагдах эрсдэлтэй байна.

3.2.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалтуудыг хэрэгжүүлэх, аливаа БНА-2019/21/СТА-ТТЗ)

шийдвэрийг хугацаанд нь үнэн зөв гаргаж, хяналт тавьж, баталгаажуулж байх, НДЕГ-ын дотоод хяналт шалгалтаар цалингийн зардлыг шалгуулж хариу ирүүлэх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Саналгүй.

3.3 Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн

3.3.1 Илрүүлэлт:

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, өмнөх оны алдааг давтан хуульд заасан хугацаанд санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Хууль, тогтоомжийг мөрдөөгүй байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуульд заасан хугацаанд санхүүгийн нэгтгэсэн тайланг төрийн аудитын байгууллагад ирүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 01-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,943,150,954.18</u>	<u>1,267,359,401.79</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,404,913,165.74	817,852,866.74
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,404,913,165.74	817,852,866.74
3122	Гадаад валют	1,404,913,165.74	817,852,866.74
31221	Төрийн сангийн харилцах	853,839.00	26,970.00
31223	Арилжааны банк дахь харилцах	1,404,059,326.74	817,825,896.74
33	АВЛАГА	470,784,761.04	431,711,291.45
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	276,993,158.69	386,122,141.99
33300	Татаас, санхүүжилтийн авлага	141,643,228.92	-
335	Бусад авлага	52,148,373.43	45,589,149.46
3351	Байгууллагаас авах авлага	47,841,273.43	41,678,249.46
3352	Хувь хүмүүсээс авах авлага	4,307,100.00	3,910,900.00
34	УРЬДЧИЛГАА	50,004,964.00	350,464.00

Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

34600	Урьдчилж гарсан зардал	49,654,500.00	
3471	Урьдчилгаа тооцоо	350,464.00	350,464.00
34713	Цалингийн урьдчилгаа	350,464.00	350,464.00
35	БАРАА МАТЕРИАЛ	17,448,063.40	17,444,779.60
354	Хангамжийн материал	17,448,063.40	17,444,779.60
35410	Бичиг хэргийн материал	321,120.00	306,300.00
35420	Аж ахуйн материал	7,938,575.80	7,955,075.80
35470	Бусад хангамжийн материал	9,188,367.60	9,183,403.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	609,020,866.49	676,630,614.14
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	609,020,866.49	676,630,614.14
392	Биет хөрөнгө	609,020,866.50	609,405,614.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	682,242,449.00	466,812,101.48
39202	Хуримтлагдсан элэгдэл	(253,944,571.40)	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	89,980,000.00	89,980,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(24,994,444.44)	(39,991,111.11)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	149,095,500.51	153,361,408.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	(67,231,512.78)	(94,825,800.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62,570,100.00	69,563,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,696,654.39)	(35,493,984.39)
393	Биет бус хөрөнгө	(0.01)	67,224,999.99
39301	Програм хангамж	3,700,602.00	3,700,602.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,700,602.01)	(3,700,602.01)
39303	Бусад биет бус хөрөнгө		67,225,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,552,171,820.67	1,943,990,015.93
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	173,397,259.30	219,837,893.98
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	167,654,060.30	219,837,893.98
413	Өглөг	31,383,368.54	30,214,979.60
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,005,552.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	29,327,816.54	30,164,979.60
4136	Бусад өглөг	50,000.00	50,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	50,000.00	50,000.00
414	Урьдчилж орсон орлого	136,270,691.76	189,622,914.38
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	136,270,691.76	189,622,914.38
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,743,199.00	-
422	Урт хугацаат зээл	5,743,199.00	-
4221	Төгрөг	5,743,199.00	-
42217	Санхүүгийн бусад байгууллага	5,743,199.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,378,774,561.37	1,724,152,121.95
51	Засгийн газрын хувь оролцоо	2,378,774,561.37	1,724,152,121.95
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	253,719,660.30	320,944,660.30
51101	Өмч: - төрийн	253,719,660.30	320,944,660.30
512	Хуримтлагдсан үр дүн	2,022,634,300.20	1,183,752,751.60
51210	Өмнөх үеийн үр дүн	970,498,962.31	1,831,167,798.29
51220	Тайлант үеийн үр дүн	1,052,135,337.89	(647,415,046.69)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	102,420,600.87	219,454,710.05

Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,552,171,820.67	1,943,990,015.93
---	--	-------------------------	-------------------------

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх гүйцэтгэл оны	Тайлант гүйцэтгэл оны
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	67,953,714,322.62	73,819,587,997.21
11	ТАТВАРЫН ОРЛОГО	16,100,060,230.54	16,495,237,672.33
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	16,100,060,230.54	16,495,237,672.33
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	9,187,626,464.04	11,197,687,358.04
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,142,459,542.79	1,226,345,735.42
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	697,913,335.66	771,776,654.57
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	215,904,595.76	226,454,126.83
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	4,856,156,292.29	3,072,973,797.47
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	71,813,098.45	100,458,800.69
120	Нийтлэг татварын бус орлого	69,556,848.45	100,458,800.69
120002	Хүүгийн орлого	39,897,089.47	59,881,274.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,175,348.98	10,445,515.60
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,820,348.98	9,258,315.60
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,355,000.00	1,187,200.00
120009	Бусад орлого	17,484,410.00	30,132,011.00
121	Хөрөнгийн орлого	2256250.00	0.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	2256250.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	51,781,840,993.63	57,223,891,524.19
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,779,600.00	7,574,333.81
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,779,600.00	4,001,708.81
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	3,572,625.00
1330	Төсвийн захирагчдаас	51,244,911,793.63	56,662,192,690.38
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,244,911,793.63	56,651,666,923.38
133003	Хөрөнгийн		10525767.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	534,149,600.00	554,124,500.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	534,149,600.00	554,124,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	66,901,578,984.73	74,393,151,646.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	66,901,578,984.73	74,393,151,646.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	574,510,228.80	573,556,934.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	385,853,366.00	382,235,969.00
210101	Үндсэн цалин	299,935,123.00	302,013,319.00
210102	Нэмэгдэл	57,739,993.00	54,050,407.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,711,003.00	9,360,499.00
210105	Гэрээт ажлын хөлс	17,467,247.00	16,811,744.00

Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		
		51,484,972.01	46,477,425.95
210201	Тэтгэврийн даатгал	28,422,943.67	31,111,988.92
210202	Тэтгэмжийн даатгал	3,664,593.37	3,843,683.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,459,402.37	3,072,157.86
210204	Ажилгүйдлийн даатгал	804,422.93	766,877.53
210205	Эрүүл мэндийн даатгал	8,133,609.67	7,682,718.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,449,000.00	33,326,018.00
210301	Гэрэл, цахилгаан	2,410,051.00	2,480,637.00
210302	Түлш, халаалт	24,989,881.00	27,503,495.00
210303	Цэвэр, бохир ус	3,049,068.00	3,341,886.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,318,035.22	11,997,344.97
210401	Бичиг хэрэг	3,601,930.00	3,656,203.00
210402	Тээвэр, шатахуун	4,293,550.00	4,639,625.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,593,143.22	2,733,016.97
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,829,412.00	968,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	759,936.00	765,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	423,136.00	209,000.00
210604	Урсгал засвар	336,800.00	556,800.00
2107	Томилолт, зочны зардал	3,519,050.00	3,583,500.00
210702	Дотоод албан томилолт	3,519,050.00	3,583,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,039,124.00	34,437,936.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,772,804.00	21,381,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	422,000.00	495,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	56,100.00	76,100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,170,990.00	5,447,310.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	117,230.00	6,437,826.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,086,745.57	60,732,940.13
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,737,420.00	2,549,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	59,349,325.57	58,183,440.13
212	ТАТААС	836,166,486.00	-
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	836,166,486.00	-
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	836,166,486.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,490,902,269.93	73,819,594,712.63
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,711,006,211.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	4,711,006,211.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,366,408,061.00	40,201,647,167.12
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	35,329,575,161.00	40,147,904,167.12
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,031,500.00	7,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,001,400.00	46,743,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,800,000.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,413,487,997.93	33,617,947,545.51

Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,413,487,997.93	33,617,947,545.51
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,052,135,337.89	(573,563,649.47)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	73851397.22
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		2735322.97
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		71116074.25
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(73,851,397.22)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,052,135,337.89	(647,415,046.69)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх гүйцэтгэл	/Төгрөгөөр/	
			оны	Тайлант гүйцэтгэл оны
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	68,287,893,530.90		73,763,952,590.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	16,381,919,780.86		16,395,742,900.53
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	16,381,919,780.86		16,395,742,900.53
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	9,380,924,142.08		11,135,632,787.25
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,169,738,539.30		1,218,996,018.87
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	712,724,356.42		769,107,844.65
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	222,371,950.97		224,494,044.17
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	4,896,160,792.09		3,047,512,205.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	142,590,013.41		175,869,403.79
120	Нийтлэг татварын бус орлого	142,590,013.41		175,869,403.79
120002	Хүүгийн орлого	39,897,089.47		59,881,274.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	102,692,923.94		115,988,129.70
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,337,923.94		114,800,929.70
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,355,000.00		1,187,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	51,763,383,736.63		57,192,340,286.18
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,779,600.00		3,572,625.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,779,600.00		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00		3,572,625.00
1330	Төсвийн захирагчдаас	51,226,454,536.63		56,634,643,161.18
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,226,454,536.63		56,634,643,161.18
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	534,149,600.00		554,124,500.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	534,149,600.00		554,124,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)			

Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

		66,885,620,782.37	74,351,012,889.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	66,885,620,782.37	74,351,012,889.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	514,486,970.23	513,768,361.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	386,963,457.00	384,036,652.00
210101	Үндсэн цалин	358,916,061.03	288,864,253.00
210102	Нэмэгдэл		63,406,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,671,003.00	11,193,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	17,376,392.97	20,571,899.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,565,519.00	46,477,425.95
210201	Тэтгэврийн даатгал	27,071,670.08	31,111,988.92
210202	Тэтгэмжийн даатгал	3,490,372.56	3,843,683.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,490,372.56	3,072,157.86
210204	Ажилгүйдлийн даатгал	766,179.34	766,877.53
210205	Эрүүл мэндийн даатгал	7,746,924.46	7,682,718.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,449,000.00	31,190,700.00
210301	Гэрэл, цахилгаан	2,410,051.00	2,480,637.00
210302	Түлш, халаалт	24,989,881.00	25,368,177.00
210303	Цэвэр, бохир ус	3,049,068.00	3,341,886.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,178,043.23	12,510,024.97
210401	Бичиг хэрэг	4,210,050.00	3,641,383.00
210402	Тээвэр, шатахуун	3,782,550.00	5,150,625.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,751,533.23	2,733,016.97
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,433,910.00	985,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	759,936.00	765,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	423,136.00	209,000.00
210604	Урсгал засвар	336,800.00	556,800.00
2107	Томилолт, зочны зардал	3,519,050.00	3,583,500.00
210702	Дотоод албан томилолт	3,519,050.00	3,583,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,314,545.00	32,654,759.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,673,902.00	21,381,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	422,000.00	495,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,100.00	76,100.00

Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,170,990.00	5,447,310.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,491,553.00	4,654,649.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,737,420.00	2,549,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,737,420.00	2,549,500.00
212	ТАТААС	836,166,486.00	-
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	836,166,486.00	-
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	836,166,486.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,534,967,326.14	73,837,244,527.58
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,711,006,211.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	4,711,006,211.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,410,473,117.21	40,219,296,982.07
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	35,338,574,690.00	40,104,186,156.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,031,500.00	7,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,065,527.21	61,367,826.07
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,001,400.00	46,743,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,800,000.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,413,487,997.93	33,617,947,545.51
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,413,487,997.93	33,617,947,545.51
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,402,272,748.53	(587,060,299.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,402,272,748.53	(587,060,299.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,640,417.21	1,404,913,165.74
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,404,913,165.74	817,852,866.74

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	253,719,660.30	102,420,600.87	940,330,404.31	1,296,470,665.48
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			30,168,558.00	30,168,558.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	253,719,660.30	102,420,600.87	970,498,962.31	1,326,639,223.48
Тайлант үеийн үр дүн			1,052,135,337.89	1,052,135,337.89
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	253,719,660.30	102,420,600.87	2,022,634,300.20	2,378,774,561.37
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	253,719,660.30	102,420,600.87	3,074,769,638.09	2,378,774,561.37
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-191,466,501.91	-191,466,501.91

Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дахин илэрхийлсэн үлдэгдэл	253,719,660.30	102,420,600.87	1,831,167,798.29	2,187,308,059.46
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		117,034,109.18		117,034,109.18
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	67,225,000.00			67,225,000.00
Тайлант үеийн үр дүн			-647,415,046.69	-647,415,046.69
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	320,944,660.30	219,454,710.05	1,183,752,751.60	1,724,152,121.95

5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	41,460,879,200.00	41,424,929,682.23	40,840,336,800.00	40,663,639,366.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	41,460,879,200.00	41,424,929,682.23	40,840,336,800.00	40,663,639,366.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	490,875,500.00	490,516,704.23	508,965,600.00	505,710,210.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	386,963,500.00	386,973,457.00	382,809,400.00	382,809,400.00
210101	Үндсэн цалин	321,592,400.00	358,926,061.03	288,265,100.00	288,265,100.00
210102	Нэмэгдэл	41,034,200.00		63,406,900.00	63,406,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,337,700.00	10,671,003.00	11,193,600.00	11,193,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,999,200.00	17,376,392.97	19,943,800.00	19,943,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,565,300.00	42,565,519.00	46,052,600.00	46,052,601.00
210201	Тэтгэврийн даатгал	27,087,500.00	27,071,670.08	30,701,800.00	30,827,611.44
210202	Тэтгэмжийн даатгал	3,869,700.00	3,490,372.56	3,837,700.00	3,808,550.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,095,000.00	3,490,372.56	3,070,200.00	3,044,076.86
210204	Ажилгүйдлийн даатгал	773,900.00	766,179.34	767,500.00	759,867.90
210205	Эрүүл мэндийн даатгал	7,739,200.00	7,746,924.46	7,675,400.00	7,612,494.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,449,000.00	30,449,000.00	31,190,700.00	31,190,700.00
210301	Гэрэл, цахилгаан	2,178,000.00	2,410,051.00	2,871,900.00	2,480,637.00
210302	Түлш, халаалт	24,914,900.00	24,989,881.00	24,962,700.00	25,368,177.00
210303	Цэвэр, бохир ус	3,356,100.00	3,049,068.00	3,356,100.00	3,341,886.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,898,000.00	11,178,043.23	11,918,600.00	11,918,599.97
210401	Бичиг хэрэг	2,479,400.00	4,210,050.00	3,219,900.00	3,641,383.00
210402	Тээвэр, шатахуун	2,279,100.00	3,782,550.00	4,559,200.00	4,559,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,291,300.00	1,751,533.23	3,291,300.00	2,733,016.97
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	848,200.00	1,433,910.00	848,200.00	985,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	765,800.00	759,936.00	765,800.00	765,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл				

Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

		336,600.00	423,136.00	336,600.00	209,000.00
210604	Урсгал засвар	429,200.00	336,800.00	429,200.00	556,800.00
2107	Томилолт, зочны зардал	3,603,100.00	3,519,050.00	3,603,100.00	3,583,500.00
210702	Дотоод албан томилолт	3,603,100.00	3,519,050.00	3,603,100.00	3,583,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,353,800.00	1,337,900.00	29,535,900.00	28,000,110.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	113,700.00	113,700.00	21,381,700.00	21,381,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	600,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	422,000.00	422,000.00	495,000.00	495,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,100.00	56,100.00	76,100.00	76,100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	14,500.00	14,500.00	6,983,100.00	5,447,310.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,789,500.00	1,789,500.00	3,089,500.00	1,389,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал			1,700,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,789,500.00	1,789,500.00	1,389,500.00	1,389,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,060,843,900.00	35,752,542,075.89	40,331,371,200.00	40,157,929,156.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,819,030,600.00	32,510,939,549.89	40,331,371,200.00	40,157,929,156.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	32,754,678,400.00	32,446,708,359.89	40,277,628,200.00	40,104,186,156.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,546,500.00	8,426,153.00	7,000,000.00	7,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	55,610,100.00	55,610,037.00	46,743,000.00	46,743,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	41,460,879,200.00	41,424,929,682.22	40,840,336,800.00	13,445,239,710.22
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	28,274,573,600.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих			28,274,573,600.00	-
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	41,460,879,200.00	41,422,574,682.22	12,565,763,200.00	13,404,960,301.38
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	35,591,930,300.00	35,771,694,173.85	12,565,763,200.00	13,404,960,301.38
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	2,355,000.00	-	40,279,408.84
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,355,000.00		39,092,208.84
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих				1,187,200.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,640,417.21		1,404,913,165.74
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,404,913,165.74		817,852,866.74
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00	1.00

Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	46.00	46.00	44.00	44.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	39.00	39.00	37.00	37.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	2.00	2.00
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00	4.00	4.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	46.00	44.00	46.00	46.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	35.00	34.00	35.00	35.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	7.00	7.00	7.00
650010	Гэрээт ажилтан	4.00	3.00	4.00	4.00